ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 31 өдөр Дугаар: 04/14 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.2 дахь заалт, Гүйцэтгэх захирлын 2016 оны 04/31 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2017 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллан, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор үе шаттай гарган танилцуулахыг газрын дарга нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭНХТАЙВАН

ДАВХАР ДААТГАЛ
ХӨДӨӨ АЖ АХУЙН ... ХУВЬЦААТ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ

*Гүйцэтгэх захирлын 2017 оны 01 дүгээр сарын 31 -ны өдрийн 04 / 14 дүгээр тушаалын Хавсралт*

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН 2017 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| д/д | | Хийж гүйцэтгэх ажлууд | Дүгнэх шалгуур үзүүлэлт | Хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Хяналт тавих албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|
| 0 | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| ***1. Давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд:*** | | | | | | |
| 1. | 1. | 20.0 мянга гаруй малчин өрхийг МИД-д хамруулж, МИД-ын борлуулалтын орлогыг 2.1 тэрбум төгрөгт хүргэх | МИД-д хамрагдсан малчин өрхийн тоо нэмэгдэж, борлуулалтын орлогын төлөвлөгөө 100 ба түүнээс дээш хувиар биелсэн байна. | 1-7 дугаар сард | Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал<br>Орлогч захирал |
| 2. | 2. | МИД-ын борлуулалтыг арилжааны банкаар дамжуулан хийх ажлыг үргэлжлүүлэх | МИД-ын зуучлагчаар ажиллах гэрээг арилжааны банктай байгуулж борлуулалт хийгдсэн байна. | 1-9 дүгээр сард | Андеррайтингийн газар<br>Ерөнхий хуульч | Орлогч захирал |
| 3. | 3. | Аймаг, сумдын удирдлагууд, орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, компанийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт тогтвортой хэрэгжүүлэх | Орон нутгийн удирдлагууд, даатгалын төлөөлөгчидтэй хамтын ажиллагаа өргөжиж, үр дүнд хүрсэн байна. | 2-9 дүгээр сард | Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал<br>Орлогч захирал |
| 4. | 4. | Газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг туршилтын журмаар хэрэгжүүлэх | Газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг амжилттай туршиж хэрэгжүүлсэн байна. | 2-10 дугаар сард | Андеррайтингийн газар<br>Бизнес хөгжил, | Гүйцэтгэх захирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслийн газар | |
| 5. | 5. | МИД болон бусад давхар даатгалын даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол, хохирол үнэлгээний актуар тооцооллыг хийх, давхар даатгалын хураамжийн орлогыг 1.2 тэрбум төгрөгт хүргэх | Давхар даатгалын даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол, хохирол үнэлгээний актуар тооцоолол үнэн зөв хийгдсэн байна.<br>МИД-ын давхар даатгалын хураамжийн орлогыг 1,180.0 сая төгрөгт, тариалангийн даатгалын давхар даатгалын хураамжийн орлогыг 26.0 сая төгрөгт, эрчимжсэн мал аж ахуй болон бусад бүтээгдэхүүний давхар даатгалын хураамжийн орлогыг 72.2 сая төгрөгт тус тус хүргэж, төлөвлөгөөгөө биелүүлсэн байна. | 1-12 дугаар сард | Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал<br><br>Орлогч захирал |
| 6. | 6. | Хөдөө аж ахуйн бусад салбарт шаардлагатай байгаа туршигдсан даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд үр дүнтэй нэвтрүүлэх | МИД-аас бусад хөдөө аж ахуйн салбарт даатгалын бүтээгдэхүүний гэрээ хийгдэж, борлуулалтын үйл ажиллагаа явагдсан байна. | 1-12 дугаар сард | Андеррайтингийн газар<br><br>Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |
| 7. | 7. | Олон улсын давхар даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын давхар даатгалын зах зээлд МИД-аас өөр бүтээгдэхүүнийг гаргах гэрээ байгуулах | Олон улсын давхар даатгалын гэрээ хийгдсэн байна. | 1-12 дугаар сард | Андеррайтингийн газар<br><br>Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал<br><br>Орлогч захирал |
| 8. | 8. | Компанийн компьютер, тоног төхөөрөмж, дотоод болон гадаад сүлжээг хэвийн ажиллагаатай байлгах, компанийн цахим хуудасны мэдээллийг сүлжээнд оруулж, олон нийтэд хүргэх | Компанийн дотоод, гадаад сүлжээ, компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | 1-12 дугаар сард | Андеррайтингийн газар<br><br>Мэдээлэл технологийн ажилтан | Гүйцэтгэх захирал<br><br>Орлогч захирал |
| 9. | 9. | МИД болон бусад давхар | МИД-ын бүртгэлийн болон | 2-8 дугаар | Андеррайтингийн | Гүйцэтгэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | даатгалын бүтээгдэхүүний бүртгэл, эрсдэл тооцооллын програм хангамжийг боловсруулах | тооцоолол хийх програм хангамжийг хөгжүүлж, шинэчлэлт сайжруулалт хийгдсэн байна. | сард | газар<br><br>Мэдээлэл технологийн ажилтан | захирал |
| ***2.Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлын хүрээнд:*** | | | | | | |
| 10. | 1. | Газар тариалангийн бүтээгдэхүүний тоог нэмж, борлуулалтыг дэмжих | Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний худалдан авагчдын цар хүрээ нэмэгдсэн байна.<br>Газар тариалангийн бүтээгдэхүүнийг хосолмол аргаар хэрэгжүүлэхэд шаардагдах судалгааг хийж, туршилтын ажлыг зохион байгуулсан байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар<br><br>Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал |
| 11. | 2. | Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх | Даатгалын тогтолцооны талаар зах зээлийн судалгаа хийж, эрсдэлийн тооцоолол хийсэн байна.<br>Давхар даатгалын нөхцөлт гэрээ батлагдсан байна. | 2-10 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар<br><br>Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал |
| 12. | 3. | Даатгалын бусад хэлбэрээр даатгагчидтай хамтын ажиллагааг эхлүүлэх | Хамтын ажиллагааг эхлүүлсэн байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар<br><br>Андеррайтингийн газар | Гүйцэтгэх захирал |
| 13. | 4. | Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах судалгаа хийх | Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах судалгааг хийж холбогдох хууль, эрх зүйн актад оруулах өөрчлөлтийн санал боловсруулан удирдлагад танилцуулсан байна.<br>Үндэсний давхар даатгалын корпорацийн эрхзүйн байдлын тухай хууль боловсруулах Ажлын хэсэгт орж | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллан хуулийн төсөл боловсруулсан байна.<br>Олон улсын давхар даатгалын корпорациудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын эхлэл тавигдсан байна.<br>Эхний ээлжинд хариуцах давхар даатгалын бүтээгдэхүүнүүдийн судалгаа, тооцоолол хийгдсэн байна. | | | |
| 14. | 5. | Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах | Хэвлэл мэдээллийн агентлаг, газруудаар дамжуулан компанийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд мэдээллэсэн байна.<br>МИД болон газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний талаар нэвтрүүлэг, танилцуулга, шторк хийлгэн хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээсэн байна.<br>Компанийн маркетингийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |
| 15. | 6. | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулах | Төслүүдтэй хамтарч ажиллаж үр дүн гарсан байна.<br>Холбогдох уулзалтуудыг зохион байгуулж, мөн зохион байгуулагдсан сургалт, семнарт оролцож, тайлан гаргасан байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |
| 16. | 7. | Үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн төсөлд шаардлагатай заалтыг тусгуулахаар саналаа өгч ажиллах | Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийн ажлын хэсэгт орж хамтарч ажилласан байна.<br>Шаардлагатай хууль, журмын төсөлд саналаа өгөх, шинээр боловсруулах ажлууд хийгдсэн байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар<br><br>Ерөнхий хуульч | Гүйцэтгэх захирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17. | 8. | Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах | Бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлангаар гарган удирдлагад танилцуулсан байна. | 1-12 дугаар сард | Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |
| ***3.Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд:*** | | | | | | |
| 18. | 1. | Шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, экспортын даатгалын чиглэлээр мэргэшүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах | Монгол Улсад экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа, эрхлэх гэж буй Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар болон экспортлож буй бүтээгдэхүүний дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээ хийгдэж, хэрэгцээтэй мэдээллийг цуглуулсан байна.<br>Сургалтын төлөвлөгөө батлагдан хэрэгжиж, сургалтанд хамрагдсан ажилтнуудын чадвар сайжирсан байна. | 1-12 дугаар сард | Экспортын даатгалын газар<br><br>Бизнес хөгжил, төслийн газар | Гүйцэтгэх захирал |
| 19. | 2. | Даатгуулагчдын шаардлага хэрэгцээнд нийцсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах | Даатгалын тухай хууль, дүрэм, журмын үнэлгээ хийгдэж, хууль, дүрэм, журам, гэрээний төсөл, үйл ажиллагааны үндсэн чиглэл боловсруулагдсан байна. | 1-12 дугаар сард | Экспортын даатгалын газар<br><br>Ерөнхий хуульч | Гүйцэтгэх захирал |
| 20. | 3. | Гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулан, хэрэгжилтийн үр дүнг хариуцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны төлөвлөгөө заалт бүрээр бүрэн хэрэгжиж, үр дүнд хүрсэн байна.<br>Хяналт шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна. | 1-12 дугаар сард | Экспортын даатгалын газар | Гүйцэтгэх захирал |
| ***4. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх, сангийн хөрөнгийг зохион байгуулалтын ажлын хүрээнд:*** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 21. | 1. | Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлтийн 3 дахь бүрдүүлэлт болох 3.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлэх | Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлтийн 3.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс компанийн дансанд шилжүүлсэн байна. | 4-7 дугаар сард | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар | Гүйцэтгэх захирал |
| 22. | 2. | Дүрмийн сан, алдагдлаас хамгаалах сан, хамтын эрсдэлийн сан, дээд болон дунд түвшний эрсдлийн сангуудын зохион байгуулалтыг хариуцах, холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулалтад байршуулах | Мөнгөн хөрөнгөөр Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, шаардлагын дагуу хөрөнгө оруулалт хийгдэж бондын өгөөж, хадгаламжийн хүүгээр өсөж арвижсан байна.<br>Хамтын эрсдэлийн сангийн дотоод журам батлагдан, хэрэгжсэн байна.<br>МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам батлагдан хэрэгжсэн байна.<br>2017 оны МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байна. | 1-12 дугаар сард | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар<br><br>Ерөнхий хуульч | Гүйцэтгэх захирал |
| 23. | 3. | МИД-ын нөхөн төлбөр олгох журмыг боловсруулж батлуулах, 2016 оны нөхөн төлбөрийг тооцоолж олгох | МИД-ын нөхөн төлбөрийн журам шинэчлэн батлагдаж, хэрэгжсэн байна.<br>Нөхөн төлбөр авах нөхцөл бүхий малчид нөхөн төлбөрөө гэрээний хугацаандаа бүрэн авсан байна. | 8-10 дугаар сард | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар<br><br>Андеррайтингийн газар | Орлогч захирал |
| 24. | 4. | Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, олгох | Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн журам шинэчлэн батлагдаж, хэрэгжсэн байна.<br>Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг | 9-11 дүгээр сард | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар<br><br>Андеррайтингийн | Гүйцэтгэх захирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох гэрээ, журмын дагуу үнэн зөв тооцоолж, олгосон байна. | | газар | |
| 25. | 5. | Компани өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар зах зээлийн судалгаа хийх | Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар олон талт судалгааны ажил хийгдэж, судалгааны баримт бичиг боловсруулагдан, ажил хэрэгжиж эхэлсэн байна. | 1-12 дугаар сард | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар | Гүйцэтгэх захирал |
| ***5. Үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах дотоод ажлын хүрээнд:*** | | | | | | |
| 26. | 1. | Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх | Хүний нөөцийн бодлого, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тухай бүр Гүйцэтгэх удирдлагаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн байна.<br>Олон нийтийн арга хэмжээний жилийн ажлын төлөвлөгөө батлагдан, бүрэн хэрэгжсэн байна.<br>Дотоод сургалтын төлөвлөгөө батлагдан хэрэгжсэн байна. | 1-12 дугаар сард | Санхүү, удирдлагын газар<br><br>Ерөнхий хуульч | Гүйцэтгэх захирал<br><br>Орлогч захирал |
| 27. | 2. | Компанийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах | Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдэн батлагдаж өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлсэн байна.<br>Ажилтан тус бүртэй хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулсан байна.<br>Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт ажилтан тус бүрээр дүгнэгдэн, ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгогдсон байна. | 1-2 дугаар сард | Санхүү, удирдлагын газрын дарга<br><br>Ерөнхий хуульч | Гүйцэтгэх захирал |
| 28. | 3. | Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хяналт тавих, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, | Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, журам, бодлогын баримт бичгүүд бүрэн хэрэгжсэн байна. | 1-12 дугаар сард | Санхүү, удирдлагын газар | Гүйцэтгэх захирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэгтгэх, тайлагнах | Санхүүгийн жил, улирлын тайлан хугацаандаа үнэн зөв гарч, холбогдох газруудад хүргэгдэн шаардлагатай үнэлгээг авсан байна. | | | |
| 29. | 4. | Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх | Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанууд хууль, журмын дагуу хэрэгжсэн байна. | 1-10 дугаар сард | Санхүү, удирдлагын газар | Гүйцэтгэх захирал |
| 30. | 5. | Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Ажилтнууд ажиллах хэвийн нөхцөлөөр хангагдсан байна.<br>Газар нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна. Албан бичиг хэргийн хөтлөлт, хадгалалт журам, зааврын дагуу явагдсан байна. | 1-12 дугаар сард | Санхүү, удирдлагын газар | Гүйцэтгэх захирал<br>Орлогч захирал |
| 31. | 6. | Ажлын байрны эмх цэгц, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллах | Оффисын байрны эмх цэгц, техник хэрэгсэл, эд хөрөнгийн хангамж, бүртгэл, хадгалалт хамгаалалт шаардлагатай түвшинд хүрсэн байна. | 1-12 дугаар сард | Санхүү, удирдлагын газар | Орлогч захирал |
| ***6. Хуулийн хэрэгжилт, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд*** | | | | | | |
| 32. | 1. | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Төлөвлөгөөнд заасан ажлыг гүйцэтгэж Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүгнүүлж шаардлагатай оноог авсан байна. | 12-р сарын 25-ны өдрийн дотор | Ерөнхий хуульч<br>Санхүү, удирдлагын газрын дарга | Гүйцэтгэх захирал |
| 33. | 2. | Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан жагсаалтад заасан албан тушаалтнуудаас ХАСХОМ-ийг холбогдох хууль тогтоомжид заасны гаргуулах | Албан тушаалтнуудаас ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах тухай хуульд заасны дагуу бүрэн авсан байна. | 2-р сарын 15-ны өдрийн дотор | Ерөнхий хуульч | Сангийн яамны эрх бүхий албан тушаалтан Буянхишиг |
| 34. | 3. | Компанийн үйл ажиллагааны | Компанийн үйл ажиллагаатай | 1-12 дугаар | Ерөнхий хуульч | Гүйцэтгэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | эрх зүйн үндэслэлийг ханган ажиллах | холбоотой хууль, журам, дүрмийн хэрэгжилт сайн байна.<br>Шаардлагатай хууль, журам, дүрмийн төсөл боловсруулагдан өргөн баригдсан байна. | сард | Газрын дарга нар | захирал<br>Орлогч захирал |
| ***7. Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын хүрээнд*** | | | | | | |
| 35. | 1. | Хууль тогтоомж, дүрэм журам, хөтөлбөр, стандарт гэрээ, арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих | Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, үнэлгээ, зөвлөмж өгөгдсөн байна. | 1-12 дугаар сард | Ерөнхий хуульч<br>Дотоод хяналтын ажилтан | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга<br>Аудитын хорооны дарга |
| 36. | 2. | Хөндлөнгийн аудит, хяналт шинжилгээний байгууллагаас хийсэн шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх, илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллах | Зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчил дутагдлыг арилгах ажлын төлөвлөгөө гарган бүрэн хэрэгжүүлсэн байна. | 1-12 дугаар сард | Дотоод хяналтын ажилтан<br>Газрын дарга нар<br>Нягтлан бодогч | Аудитын хорооны дарга<br>Гүйцэтгэх захирал |
| 37. | 3. | Компанийн төсөв, санхүү, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудитыг хийх | Компанийн санхүү, төсөв, хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, зөвлөмж гаргах, биелэлтэнд хяналт тавигдсан байна. | 4, 7 дугаар сард | Дотоод хяналтын ажилтан | Аудитын хорооны дарга |
| 38. | 4. | Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах | Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн аливаа үйл ажиллагаа, шийдвэр Компанийн тухай хууль, холбогдох бусад дүрэм, журамд бүрэн нийцсэн байна.<br>Шийдвэрүүд бүрэн хэрэгжсэн байна. | 1-12 дугаар сард | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Ерөнхий хуульч | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга |

----------------- o O o -----------------